

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН БЭЛТГЭХ,
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

Энэхүү журам нь Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Мэргэжлийн сургалт, боловсролын тухай хууль болон бусад эрх зүйн бичиг баримттай зохицон боловсруулагдсан бөгөөд төмөр замын тээврийн (цаашид салбар гэх) салбарын мэргэжилтний мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвар, бүтээл туршлагыг үнэлэх замаар тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалт, шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Энэхүү журмын зорилго нь салбарт ажиллаж буй мэргэжилтэй ажилтны мэргэжлийн ур чадварыг орчин үеийн техник, технологийн чиг хандлага, салбарын хөгжил дэвшлийн чиг хандлага, салбарын хөгжил дэвшлийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлэхэд чиглэнэ.

1.1. Энэхүү журамд орсон үг хэллэгийг дараах байдлаар ойлгоно.Үүнд;

1.1.1. Мэргэжлийн стандарт гэдэг нь тодорхой төрлийн мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэшлийн шинж байдал, онцлогийг хэлнэ.

1.1.2. Мэргэжлийн ажилтан, албан хаагчдыг бэлтгэх мэргэжлийн сургалтын хөтөлбөр гэдэгт өмнө нь тухайн мэргэжлийг эзэмшээгүй ажилтан, албан хаагчдыг сургах үйл ажиллагааг хэлнэ.

1.1.3. Мэргэжилтэй ажилтан, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах хөтөлбөрөөр мэргэжлийн сургалт зохион байгуулах гэдэгт; холбогдох мэргэжлийг эзэмшсэн албан хаагч, мэргэжилтэн эсвэл мэргэжлийн ажилтанд тэдгээрийн боловсролын түвшинг дээшлүүлэхгүйгээр дэс дараалалтайгаар мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагад суурилсан мэдлэгийг дээд түвшинд нь хүргэх мэргэжлийн бүхий л төрлийн сургалт багтана.

1.1.4. Мэргэжилтэй ажилтан, мэргэжилтнүүдийг давтан сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн сургалт явуулах зохион байгуулах гэдэгт мөн холбогдох мэргэжлийг эзэмшсэн албан хаагч, мэргэжилтэн эсвэл мэргэжлийн ажилтанд үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны төрлөөс хамааран албан хаагчийн шинэ ажлын байр эсвэл ажилтны шинэ мэргэжлийг олгох зорилго бүхий мэргэжлийн сургалтыг зохион байгуулна. Энэхүү сургалтыг төгссөний дараа ажилтан, албан хаагч нь өөр мэргэжлээр шинэ техникийн орчинд ажиллах боломжтой болно.

Ажилтанд хоёрдох мэргэжлийг эзэмшүүлэх, албан хаагчийг өөр ажлын байранд шилжүүлэхтэй холбоотой сургалтын хөтөлбөр нь судалгаа, шаардлагад үндэслэн тухайн үйлдвэрлэлийн үйл явцад цаашид шаардлагатай өөр төрлийн ажил мэргэжлээр ажилтан албан хаагчдыг сургаж бэлтгэх үйл явц байна.

1.1.5. Мэргэжилтэй ажилтан гэдэгт төмөр замын тээврийн салбарын хэрэгцээ шаардлагын дагуу гадаад, дотоодын мэргэжлийн боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт хамрагдаж төгсөн холбогдох гэрчилгээ, диплом авсан, мэдлэг, ур чадвар, ажлын туршлага, практик туршлагад үндэслэн мэргэжлийн чиглэлийн гарсан хүндрэлтэй асуудлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн үйл ажиллагааны тодорхой төрлийг гүйцэтгэхээр бэлтгэгдсэн, төмөр замын байгууллагын ямар нэг ажлын байранд ажиллаж байгаа мэргэжилтэн, удирдах албан тушаалтан, мэргэжлийн ажилтан, техникч нарыг,

1.1.6. Удирдах ажилтан болон мэргэжилтнүүдийн мэргэжлийн давтан сургалт гэдэгт; шинжлэх ухааны, техникийн, үйл ажиллагааны зохион байгуулалтын болон эдийн засгийн шинэ санааг практикт нэвтрүүлэх боломжийг хангах, удирдах ажилтан мэргэжилтнүүдийг хүний нөөцийн бэлтгэх, тэдгээрийг нийгэм эдийн засгийн шинэ нөхцөлд дасан зохицох, мөн олон улсын стандарт, тавигдах нөхцөл шаардлагад шаардлагатай ур чадвар, мэргэжлийн мэдлэгийг олж авахад дэмжлэг үзүүлэх сургалт,

1.1.7. Мэргэшил гэдэг нь; тодорхой төрөл болон хамрах хүрээний мэргэжлийн онцлог

шаардлагад үндэслэн техникийн шийдэл шаардсан асуудалд шийдвэр гаргаж хэрэгжүүлэхэд ажилтанд шаардлагатай мэргэшлийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийн дагуу авсан тодорхой үйл ажиллагаа явуулах эрх бүхий гэрчилгээтэй төмөр замын тээврийн мэргэжилтэн,

1.2. “Төмөр замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалт зохион байгуулах шалгалт авах журам” нь дараах хавсралтуудаас бүрдэнэ. Үүнд;

- “Төмөр замын мэргэжлийн ажилтныг бэлтгэх, давтан сургах сургах, шалгалт авах журам”-ыг энэхүү журмын нэгдүгээр хавсралт,
- “Төмөр замын мэргэжилтэй ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох нийтлэг журам”-ыг энэхүү журмын хоёрдугаар хавсралт,
- “Төмөр замын салбарын мэргэжилтний тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалт, шалгалт авах журам”-ыг энэхүү журмын гуравдугаар хавсралт.

**ТӨМӨР ЗАМЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛТНЫГ БЭЛТГЭХ, ДАВТАН СУРГАХ,
ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ**

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ.

1.1 Энэхүү журмаар төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалт, давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх, шалгалт авах үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Төмөр замын тээврийн салбарын мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалтын зорилго нь үндэсний мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшинд заагдах төмөр замын мэргэжлийн болон техникийн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд Төмөр замын тээврийн тухай хууль, техник ашиглалтын багц дүрэм, холбогдох стандарт, дүрэм, журамд тавигдсан нөхцөл шаардлагын дагуу, ажлын дадлага олгох, аюул осолгүй ажиллах соёл, зан үйлд төлөвшүүлэхэд оршино.

2. ТӨМӨР ЗАМЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛТНЫГ БЭЛТГЭХ, ДАВТАН СУРГАЛТ

2.1 Салбарын мэргэжлийн ажилтныг бэлтгэх, давтан сургах сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах үйл ажиллагааг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон энэхүү журам мөн холбогдох нийтээр мөрдөх дүрэм, журам, стандартаар зохицуулна.

2.2 Мэргэжлийн сургалтын үндсэн хөтөлбөрүүд нь дараах хэлбэртэй байж болно. Үүнд;

- Мэргэжлийн ажилтан, албан хаагчдыг бэлтгэх мэргэжлийн сургалтын хөтөлбөр,
- Ажилтан албан хаагчдын мэргэшил дээшлүүлэх, давтан сургах сургалтын хөтөлбөр

2.3 Галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой төмөр замын мэргэжлийн ажилтнуудыг бэлтгэхдээ төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөн, холбогдох төрийн захиргааны байгууллагуудаар батлагдсан мэргэжлийн боловсрол, сургалтын болон дээд боловсролын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.4 Галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой төмөр замын мэргэжлийн ажилтнуудыг бэлтгэх чиглэлд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр нь төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх салбарын мэргэжлийн орон тооны бус зөвлөлөөр дэмжигдсэн, холбогдох төрийн захиргааны байгууллага баталсны дагуу өөр өөр түвшний ажилтнуудыг бэлтгэх зохион байгуулалтын хэлбэр, арга барил, хэрэгсэл, бодлогын тасралтгүй байдлыг хангасан байх ёстой ба тээврийн хэрэгсэл болон суурь бүтцийн объектуудыг ашиглах чиглэлд онолын, тоног төхөөрөмжийн (ажлын байрны), практик, дадлагажуулалтыг багтаасан байна.

**3. ТӨМӨР ЗАМЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1 Төмөр замын тээврийн салбарын мэргэжлийн ажилтан, албан хаагчийг бэлтгэх сургалтыг зохион байгуулах байгууллага нь мэргэжлийн боловсролын болон техникийн боловсрол олгох үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий төмөр замын тээврийн багц дүрэм, техникийн баримт, бичиг, стандартыг тусгасан мэргэжлийн ажилтан бэлтгэх болон давтан сургалтын хөтөлбөртэй, түүнд нийцсэн багаж, тоног төхөөрөмж, сургалтын орчин, дадлага, туршилтын баазтай байна.

3.2 Галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой төмөр замын мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэх болон бүхий л төрлийн давтан сургалтыг (“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс”-ийн “Мэргэжлийн сургалт”-ын I-II, II-III түвшин)-ны сургалтыг холбогдох төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхийг авсан техникийн боловсролын сургалтын байгууллага, харин ажлын байрны давтан сургалтыг төмөр замын тээврийн суурь бүтэц эзэмшигч болон түүний харьяа аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдөө болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

3.3 Мэргэжилтэй ажилтныг давтан сургах үйл ажиллагаа нь ажилтны мэргэжлийн мэдлэг, ур чадварын хамрах цар хүрээг өргөсгөх, шинэ мэргэжил олгох, хөдөлмөр зохион байгуулалтын шинэчлэгдэж байгаа нөхцөл байдалд дасан зохицоход бэлтгэх гэсэн үндсэн сургалтын зорилгоосоо гадна ажилтны ажлын байрыг өөрчлөх, цомхотгох үед дахин шинэ ажлын байраар хангах зорилгоор мөн аж ахуйн үйл ажиллагаанд шинээр үүсч буй нөхцөл шаардлагатай уялдан мэргэшүүлэх зорилтын үүднээс зохион байгуулагдана.

3.4 Төмөр замын тээврийн суурь бүтэц эзэмшигч болон аж ахуйн нэгж, байгууллага нь төмөр замын тээврийн салбарын мэргэжлийн ажилтанд мэргэжлийн зэрэг олгох сургалт, тэдгээрийг дадлагажуулах, мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжлийн боловсрол олгодог сургалтыг өөрийн материаллаг бааз болон техникийн орчинд мөн сургалт зохион байгуулах эрхийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас журмын дагуу авсан, өөрийн сургалтын орчин, техникийн бааз болон багшлах бүрэлдэхүүнтэй, боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс”-ээр зөвшөөрөгдсөн хамрах хүрээ, үргэлжлэх хугацаагаар зохион байгуулах сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

3.5 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төмөр замын тээврийн салбарын галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой мэргэжлийн ажилтан бэлтгэх, давтан сургах сургалтыг зохион байгуулах хүсэлтэй хуулийн этгээдэд холбогдох үйл ажиллагааны гэрчилгээг олгохдоо төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай заавал зөвшилцсөн байна.

3.6 Төмөр замын тээврийн салбарын галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой мэргэжлийн ажилтан бэлтгэх, давтан сургах сургалтыг зохион байгуулах хүсэлтэй хуулийн этгээд нь энэ тухай хүсэлтийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад зэрэг хүргүүлнэ.

3.7 Төмөр замын тээврийн салбарын галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой мэргэжлийн ажилтныг давтан сургах сургалтыг зохион байгуулах хүсэлтэй мэргэжлийн сургалтын байгууллага нь холбогдох төрийн захиргааны байгууллагуудын баталсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”-аар зохицуулсан нөхцөл шаардлагаас гадна төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журмын дагуу тавигдах нөхцөл шаардлагыг хангасан байна.

3.8 Төмөр замын тээврийн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн байгууллагын ирүүлсэн материалыг судалж сургалт явуулж, үнэлгээ өгөх эрхийг олгох, сунгах эсэх талаарх санал, дүгнэлтийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилна.

3.9 Журамд заагдсан холбогдох төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй цахим хэлбэрээр холбогдон сургалттай холбоотой мэдээлэл өгөх, нөхцөл бүрдүүлсэн байна.

3.10 Төмөр замын мэргэжлийн ажилтны сургалт явуулах, үнэлгээ өгөх эрх бүхий байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас баталсан маягтын дагуу

сургалтад хамрагдсан ажилтны талаарх болон холбогдох мэдээллийг тайлангийн хамт Статистикийн тухай хуульд заасны дагуу холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ.

3.11 Төмөр замын галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой мэргэжилтэй ажилтан бэлтгэх болон бүхий л төрлийн давтан, мэргэшүүлэх сургалтыг энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.5.1, 2.5.7 зааснаас бусад хувь хүн болон хуулийн этгээд зохион байгуулахгүй.

3.12 Төмөр замын тээврийн суурь бүтэц эзэмшигч болон түүний харъяа аж ахуйн нэгж, байгууллагууд нь галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой төмөр замын мэргэжлийн ажилтнуудыг давтан сургах богино хугацааны сургалтыг шаардагдах төрлүүдээр зохион байгуулах хөтөлбөртэй байх ба хөтөлбөрүүд нь алба, нэгжийн сургалт хариуцсан албан тушаалтнаар боловсруулагдан, хянагдаж алба, нэгжийн дарга баталж албажуулна.

3.13 Мэргэжлийн ажилтнаар үндсэн ажлынх нь чиг үүрэгтэй ойролцоо ажлыг хослуулан гүйцэтгүүлэх, эсвэл ажлын байр солигдох, ажлын байранд шинэ техник технологи нэвтэрсэн тохиолдолд давтан сургалтын хэлбэрүүд болох ур чадвар, мэдлэг дээшлүүлэх, шинэ техник технологи эзэмшүүлэх сургалтуудад холбогдох хөтөлбөрийн дагуу заавал хамруулж дотооддоо баримтлах журмын дагуу эх нь төмөр замын байгууллагын холбогдох түвшинд батлагдсан гэрчилгээг олгоно.

3.14 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой үйл ажиллагаанд оролцдог төмөр замын мэргэжлийн ажилтнуудыг давтан сургах байгууллагад мэргэжлийн сургалтын “чадамжид суурилсан сургалт” зохион байгуулах үйл ажиллагааны гэрчилгээг олгохгүй.

3.15 Төмөр замын байгууллагын зүгээс мэргэжлийн ажилтныг мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад хамруулах чиглэлд тодорхой төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэхээр эрх бүхий сургалтын байгууллагад захиалга өгөх, шаардлагатай зардлыг төсөвт тусгаж ажиллах ба сургалтад хамрагдсан хугацааг ажилласан хугацаанд хамруулан ажлын үр дүнтэй холбон тооцох, мөн ажлын байрнаас тусдаа сургалтад хамрагдах тохиолдолд унаа, томилолтын зардал, мөн дундаж цалинг олгох зэргээр урамшуулан дэмжих бодлогыг баримталж, холбогдох дүрэмд журамд тусгасан байна.

4. Шалгалт авах журам

4.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь мэргэжлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журмын дагуу мэргэжлийн давтан сургалтад хамрагдсан иргэдээс авах шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулна.

4.2 Төмөр замын тээврийн суурь бүтэц эзэмшигч болон түүний харъяа аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдөө ажлын байрны давтан сургалтыг явуулах бол дотооддоо шалгалт авах тухай журмыг боловсруулж мөрдөж ажиллана.

4.3 Холбогдох сургалтыг явуулах болон шалгалт авч, үнэлгээ өгөх этгээд нь суралцагчдаас мэдлэг, ур чадвар, дадлага илүү байх гэсэн шаардлагыг холбогдох диплом, гэрчилгээ, хийсэн ажлын бүтээл, тайлан зэргээр нотлогдсон байна.

5. Хариуцлага.

5.1 ТЗТС-н мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан сургалтын хөтөлбөр нь агуулга хангахгүй, хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцээгүй, эсхүл аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гомдол ирүүлсэн болон үйлдвэрлэлийн осол, зөрчил сургалтын байгууллагын буруугаас болсон гэж дүгнэлт гарсан тохиолдолд сургалт зохион байгуулах гэрчилгээг цуцлах, түдгэлзүүлэх асуудлыг журамд заагдсан төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

5.2 ТЗТС-н сургалт зохион байгуулах гэрчилгээ аваагүй, гэрчилгээний хугацаа дууссан байгууллага сургалт явуулсан тохиолдолд боловсролын хяналтын улсын байцаагч хууль тогтоомжид заасан эрхийнхээ дагуу арга хэмжээ авна.

5.3 Энэхүү журмын 2 дугаар хэсгийн 2.5.11 -ийг зөрчин холбогдох сургалтыг зохион

байгуулсан, төмөр замын галт тэрэгний хөдөлгөөн болон сэлгээний ажилтай шууд холбоотой мэргэжлээр олгосон чадамжийн гэрчилгээг хүчингүйд тооцон, түүнийг үндэслэн ажилд авах эрх үүсэхгүй болно.

5.4 Энэхүү журмын 2 дугаар хэсгийн 2.5.14-ийг зөрчин гэрчилгээ олгосон тохиолдолд зохион байгуулж байгаа үйл ажиллагааг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зүгээс холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтын дүрэм, журмаар олгогдсон хэм хэмжээнд таслан зогсоох эрхтэй.

ТӨСӨЛ.

ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, ДАВТАН СУРГАХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү журмаар төмөр замын салбарын /цаашид салбар гэх/ мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах, хяналт тавих үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журамд орсон үг хэллэгийг дараах байдлаар ойлгоно.

- Мэргэшил гэдгийг: зэрэг горилочч нь өөрийн мэргэжлийн болон ажлын байрны үйлчлэх хүрээнд тодорхой хүндрэл бүхий хөдөлмөрийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд бэлэн байдал,

- Мэргэшлийн гэрчилгээ гэдгийг: шалгалтын комиссын гаргасан саналыг үндэслэн Орон тооны бус зөвлөлийн гаргасан шийдвэрийг үндэслэн олгосон гэрчилгээн дээрхи этгээд нь тухайн гэрчилгээнд заасан салбарт мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай онолын болон практикийн, ажлын туршлага, ур чадварын хангалттай түвшин эзэмшсэнийг илтгэх баримт бичиг,

- Мэргэшлийн зэрэгт тавигдах шаардлага гэдгийг, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг багтаасан горилоччийн зүгээс хангасан байх ёстой тавигдах нөхцөл шаардлагын багцыг,

- Төмөр замын салбарын мэргэжилтэн гэдэгт төмөр замын зам, барилга, гүүр хиймэл төхөөрөмж, дохиолол холбоо, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэр зохион байгуулалтын, тээврийн эдийн засаг, төмөр замын зам, гүүрийн зураг төслийн инженерүүд хамаарагдана.

1.3 Инженер нь мэргэшсэн, зөвлөх гэсэн зэргийн шатлалтай байна.

1.4 Төмөр замын мэргэжилтэй ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах, хяналт тавих үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/ - хүлээнэ.

1.5 Салбарын мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтын үйл ажиллагааг төмөр замын инженер бэлтгэх тусгай зөвшөөрөлтэй дээд боловсролын байгууллага болон энэхүү журмын тавигдах нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээд хэрэгжүүлж болно.

1.6 Энэхүү журмыг чанд баримтлан мөрдөж олгосон мэргэшлийн зэрэг бүхий төмөр замын мэргэшсэн инженерүүдийг Хөдөлмөрийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт

заасны дагуу эсвэл байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн ажил олгогчийн олгогчийн зүгээс хөхиүлэн дэмжиж ажиллах бөгөөд холбогдох бүтээл, хамгаалалтын үр дүнг харуулсан баримт бичигт үндэслэн ажилтанд зэргийн нэмэгдлийг олгоно.

2. Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл

2.1 Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөлийн бүрэлдэхүүнийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга батална.

2.2 Зөвлөл нь хамгийн багадаа 5 хүний бүрэлдэхүүнтэй байх ба дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Орон тооны бус зөвлөлийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төмөр замын асуудал хариуцсан нэгжийн дарга ахалж ажиллана.

2.3 Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг явуулах журам, хурлын дэгтэй байна. Зөвлөлийн үйл ажиллагааны шийдвэр гаргах дээд шат нь Орон тооны бус зөвлөлийн хурал байна.

2.4 Зөвлөлийн хурал нь 75 буюу түүнээс хувийн ирцтэйгээр хуралдана.

2.5 Зөвлөл нь дор дурдсан эрх, үүрэгтэй.

2.5.1 Зөвлөл нь салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах, хэлэлцэж шийдвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.5.2 Зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд нь салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журмын хүрээнд удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.5.3 Зөвлөлийн бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувь нь өндөр мэргэшилтэй, тухайн салбарт олон жил, үр бүтээлтэй ажилласан туршлагатай, гадаад улс оронд 30-аас доошгүй багц цагийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, олон улсын зөвлөх инженерийн байгууллагын эрх зүйн орчныг судалсан, техникийн шинжлэх ухааны доктор, аспирант, инженер- эрдэм шинжилгээний ажилтан байж болно.

2.5.4 Зөвлөл нь зөвлөх инженерийн зэрэг гориллогчдын зэрэг хамгаалах сэдвийг салбарын өмнө тулгамдсан сэдвүүдээр бүтээлийн тайлан боловсруулж хамгаалуулах чиглэлд санал оруулах эрхтэй.

2.5.5 Зөвлөл дэргэдээ төмөр замын салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөл (цаашид Технологийн зөвлөл гэх)-тэй байна. Энэхүү Технологийн зөвлөл нь зөвлөх инженерийн зэрэг олгохтой холбоотой бүтээлийн тайланг хянах, шалгах, тайлбар авах, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулж гүйцэтгэх ба өөрийн дүрэмтэй байна.

2.5.6 Орон тооны бус зөвлөл нь салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг хянах, шалгалт авч үнэлгээ өгөх эрх бүхий шалгалтын комиссыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилно. Шалгалтын комиссыг зөвлөлийн гишүүн ахална.

2.5.7 Зөвлөлөөс гаргасан сургалттай холбоотой аливаа шийдвэр нь салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталгаажсанаар хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

2.5.8 Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүргийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцах ба Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, бусад холбогдох

мэдээллээр зөвлөлийг хангах ажлыг хариуцна. Нарийн бичгийн дарга хуралд саналын эрхгүй оролцоно.

2.5.9 Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сургалтын байгууллагатай хамтран салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, сунгах сургалтын нэгдсэн хөтөлбөрийг жил тутам шинэчлэн баталгаажуулж хэрэгжүүлнэ.

2.5.10 Зөвлөлөөс мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах хугацааг баталгаажуулан тухайн оны эхэнд олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж мэдэгдэнэ. Харин мэргэшлийн зэрэг олгох сургалтын талаарх мэдээллийг тухайн сургалт явагдахаас 2 сараас доошгүй хугацааны өмнө зарлаж мэдээлнэ. Бүртгэлийг тухайн сургалт зохион байгуулах, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох журмын дагуу эрх авсан дээд боловсролын сургалтын болон сургалтын байгууллагууд зохион байгуулна.

2.5.11 Зөвлөл нь сургалтын байгууллагаас холбогдох сургалтыг зохион байгуулахаас ажлын 10 хоногийн өмнө ирүүлсэн сургалтад хамрагдах хүсэлтэй мэргэшсэн болон зөвлөх зэрэг горилогчдын ажилласан жил, бүтээл, мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамрагдсан байдал, мэргэжлийн хүрээний чиглэлд зөвлөх инженерийн удирдлага доор ажилласан төсөл хөтөлбөрийн тухай мэдээлэл зэргийг агуулсан баримт, материалуудыг хянаж зэрэг горилогчдыг сургалтад хамруулах эсэх талаар санал хүргүүлнэ.

2.5.12 Зөвлөл нь мэргэшсэн инженерийн сургалт зохион байгуулсны дараа шалгалтын комиссын ажилласан тайлан, үнэлгээний талаарх дүнг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5.13 Зөвлөх инженерийн зэрэг горилох сургалтын хувьд горилогч нь холбогдох шалгалтад амжилттай үнэлгээ авсан тохиолдолд бүтээл хамгаалалтыг Зөвлөлөөс зохион байгуулах ба шалгалтын үр дүнг хавсарган нэгдсэн байдлаар хийсэн үнэлгээг үндэслэн шийдвэрийг гаргана. Бүтээл хамгаалалттай холбоотой зөвлөлийн зардлыг сургалт зохион байгуулсан эрх бүхий сургалтын байгууллага гаргана.

2.5.14 Зөвлөл нь зөвлөх инженерийн зэрэг горилогчдын зэрэг хамгаалах сэдвийг салбарын өмнө тулгамдсан сэдвүүдээр бүтээлийн тайлан боловсруулж хамгаалуулах чиглэлд санал оруулах эрхтэй.

2.5.15 Мэргэшлийн зэрэг бүхий мэргэжилтний мэргэжлийн алдаа, дутагдал гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон, мөн ёс зүйн зөрчил илэрсэн тохиолдолд мэргэшлийн зэргийг цуцлах талаар Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй.

2.5.16 Мэргэжлийн шийдвэрийг цуцлах шийдвэр гарсантай холбогдуулан холбогдох мэргэшлийн зэргийн гэрчилгээ, тэмдгийг хураан авах эсвэл хүчингүйд тооцох ажлыг Зөвлөл зохион байгуулна.

2.5.17 Зөвлөл нь сургалт, шалгаруулалттай холбогдон гарсан аливаа маргаан, гомдол, санал, хүсэлтийг энэхүү журам болон холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

2.5.18 Зөвлөл нь мэргэжлийн хамрах хүрээнд магадлан итгэмжлэл хийх шаардлагатай төсөл хөтөлбөрийг хянах, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх зэрэг ажлуудад шаардлагатай мэргэшлийн зэрэг бүхий мэргэжилтнүүдийг санал болгох, дээрхи мэргэжилтнүүдийн материалыг хянах, нотлох үйл ажиллагаа, мэргэжилтнүүдийн талаарх салбарын нэгдсэн санг хөтөлж, холбогдох төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд байршуулж ажиллана.

2.5.19 Орон тооны бус зөвлөл нь мэргэшсэн зэрэг бүхий мэргэжилтэй ажилтнуудын талаарх мэдээллийг агуулсан мэдээллийн санг холбогдох програмыг ашиглан бүрдүүлж ажиллана.

Үүнд:

- Сургалтад хамрагдсан хөтөлбөр, хугацаа, огноо,
- Шалгалт өгсөн огноо,
- Хамгаалсан сэдэв хийсэн бүтээлийн нэр, ач холбогдлыг харуулсан мэдээлэл, хянасан зөвлөх инженерийн мэдээлэл ,огноо,
- Гэрчилгээний мэдээлэл: гэрчилгээ олгосон тушаалын дугаар, огноо, хамрах хүрээ, хүчинтэй хугацаа эхлэх, дуусах,
- Гэрчилгээний хүчинтэй хугацаанд орсон өөрчлөлтүүдийг тэмдэглэсэн байх, (цуцалсан, сэргээсэн,) зэрэг болон бусад шаардлагатай мэдээллүүд.

2.5.20 Зөвлөл нь мэргэжил дээшлүүлэх болон мэргэшүүлэх сургалт, түүний хамрах хүрээ, хөтөлбөр, хугацаа, байршил, багшлах боловсон хүчин, сургалтын орчны талаар болон тухайн хуанлийн жилд төмөр замын тээврийн салбарын зөвлөх инженерийн зэрэг хамгаалах батлагдсан бүтээлийн тайлангийн сэдвийг, мөн салбарын хэмжээний мэргэжлийн зэрэгтэй инженерүүдийн талаарх мэдээллийг нийтэд ил тод байдлаар төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд заавал байршуулах ба гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтын талаарх мэдээллийг мөн тавьж болно.

2.5.21 Зөвлөл нь энэхүү журам болон холбогдох дүрэм, журмыг чанд баримтлан ашиг сонирхлын зөрчилгүй, үнэнч шударга ажиллах үүрэгтэй.

3. МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГТЭЙ МЭРГЭЖИЛТНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, норм стандарт, дүрэм, журам, зааврын дагуу мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж, инженерийн ёс зүйг чанд баримтлан, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж ажиллана.

3.1.2 Мэргэшсэн зэрэгтэй инженер нь:

- Гэрчилгээнд заасан мэргэжлийн хамрах хүрээнд мэргэжлийн инженерийн үйл ажиллагааны хүрээнд удирдах ажилтнуудад санхүү, техник, технологи, хууль зүй, шинжээчийн үйл ажиллагааны өргөн хүрээнд зөвлөгөө өгөх мөн үйл ажиллагааны хүрээнд зөвлөмж, зөвлөгөө, шинжилгээний хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх,
- Инженерийн байгууламжийг ашиглалтад хүлээн авахад оролцох,
- Инженерийн төслийн зохиогч болох,
- Инженерийн төслийг боловсруулж байгаа зохиогчийн багийг удирдах, ахлах,
- баримт бичгийн боловсруулалтын ажилд гэрээний үндсэн дээр хамтран гүйцэтгэгчийг татан оролцуулах,
- Өөрийн инженерийн үйл ажиллагааны хүрээнд ажил гүйцэтгэх дүрэм, журам, стандарт боловсруулах,
- Инженерийн байгууламжийн барилгын ажлын явцад зохиогчийн болон инженерийн хяналтыг тавих,
- Хөрөнгө оруулалт, инженерийн байгууламжийн ашиглалт болон барилгын ажлын чиглэлээр зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах зэрэг эрхтэй.

3.1.3 Зөвлөх инженер нь дараах зөвлөх үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөлд бизнесийн санаа боловсруулах,
- Хөрөнгө оруулалтын төсөл нь хэрэгжих боломж, зорилготой нийцсэн эсэхийг судлах,
- Хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүү-эдийн засаг, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн дутагдалтай талуудад дүгнэлт хийх,
- Хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх хугацаа, арга хэмжээг төлөвлөх,
- Ажлын төслийг боловсруулах, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах,
- Хөрөнгө оруулалтын төслүүдийг удирдах,
- Барилгын ажилд байгууллагын өөрийн талаас оруулах мөнгөн хөрөнгийг өрсөлдөх чадвар, үр ашигтай байдлыг дээшлүүлэх ажлыг идэвхижүүлэх,
- Томоохон хөрөнгө оруулалтын төслүүдээс хамгийн хамгийн бага хугацаанд хамгийн задлраа хэрэгжүүлж болох төслийн гэрээний сонголтыг хийх,
- объектыг ашиглалтад хүлээн авахад болон барилгын үйл ажиллагаанд тодорхой үечлэл бүхий удирдлагын нэг функцийн дагуу хяналт явуулах мөн багц хуулийг хэрэгжүүлэх зорилготойгоор тасралтгүй байнгын хяналт тавих,
- Ямар нэг төхөөрөмжийг шинээр үйлдвэрлэхэд оролцон тухайн туршиж буй объектын шинж чанарыг судлан тэмдэглэж авах,
- Ямар нэг тоног төхөөрөмж, техникийн угсрах, нийлүүлэх ажлыг зохион байгуулах,

Мөн:

- мэргэшсэн инженерийн адил хувиараа инженерийн үйлчилгээг үзүүлэх, инженерингийн компанийг удирдах, томоохон барилгын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Ашиглалт болон төслийн баримт бичиг боловсруулалтад гэрээний үндсэн дээр туслан гүйцэтгэгчүүдийг татан оролцуулах эрхтэй.

3.1.3 Зөвлөх ба мэргэшсэн инженер, мэргэшсэн болон тэргүүлэх зэрэгтэй төсөвчин нь хавсралтаар баталсан загвар бүхий гэрчилгээ, баталгааны тэмдэгтэй байна.

3.1.4 Мэргэжлийн зэргээ цуцлуулсан мэргэжилтэн Зөвлөлд гэрчилгээ, баталгааны тэмдгийг хураалгах үүрэгтэй.

3.1.5 Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь өөрийн бие дааж гүйцэтгэсэн болон удирдсан ажлын чанарыг хянаж, баталгаажуулсан үр дүн болон өөрийн буруугаас учирсан хохирлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүрэн хариуцна.

Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох хүрээ

- Зүтгүүр, зүтгүүрийн инженер,
- Вагон, вагоны инженер,
- Төмөр зам, замын барилгын инженер,
- Төмөр замын дохиолол, холбооны ашиглалт, засварын инженер,
- Төмөр замын тээвэр зохион байгуулалтын инженер,
- Төмөр замын тээврийн инженер, эдийн засагч

ТӨСӨЛ

**“ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ ТАСРАЛТГҮЙ МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ, ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ”**

-

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

1.1 Энэхүү журам нь төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвар, бүтээл туршлагыг үнэлэх замаар тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалт, шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журмын зорилго нь төмөр замын салбарт ажиллаж буй инженерийн, мэргэжлийн ур чадварыг орчин үеийн техник, технологийн чиг хандлага, салбарын хөгжил, дэвшлийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлэхэд чиглэнэ.

1.2.1 Салбарын удирдах ажилтан болон мэргэжилтэнг тасралтгүй сургах үйл ажиллагаа нь тэдгээрийн мэргэшил дээшлүүлэх, давтан сургалт юм. Удирдах ажилтны ажлын байрны өсөлт, үйлдвэрлэлийн орчны шинэчлэлтэй холбоотойгоор хөдөлмөрийн нөхцөл шаардлагад шинээр бий болж байгаа өөрчлөлт нь мэргэшил дээшлүүлэхийг шаардаж байдаг. Удирдах ажилтан болон мэргэжилтэнгүүдийн тодорхой төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар, өрсөлдөх чадвар, туршлага, мэдлэгээ хөгжүүлэх, боловсронгуй болгоход чиглэсэн бүхий л төрлийн сургалтууд багтана.

Үүнд:

1.2.2 Удирдах ажилтан болон мэргэжилтэнгүүдийн тодорхой төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар, өрсөлдөх чадвар, туршлага, мэдлэгээ хөгжүүлэх, боловсронгуй болгоход чиглэсэн бүхий л төрлийн сургалтууд багтана. Удирдах ажилтны ажлын байрны өсөлт, үйлдвэрлэлийн орчны шинэчлэлтэй холбоотойгоор хөдөлмөрийн нөхцөл шаардлагад шинээр бий болж байгаа өөрчлөлт нь мэргэшил дээшлүүлэхийг шаардаж байдаг.

1.2.3 Удирдах ажилтны шинэ мэргэжил олгох сургалт нь боловсон хүчнийг сольж шинэчлэх ажлыг түргэн шуурхай хийх, шинжлэх ухаан техник, нийгмийн хөгжил дэвшлийн шинэ чиглэлүүдээр шинэ боловсон хүчнийг сургах, мөн хуучирсан удирдлага болон үйл ажиллагааны чиглэлүүдийг шинэчлэх зорилгоор хийгддэг үйл ажиллагаа байна.

1.3 Удирдах ажилтан болон мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалт нь дараах хэлбэртэй байж болно.

- Системтэйгээр өөрийгөө боловсруулах,
- Техникийн болон эдийн засгийн их, дээд сургуулиудад, мөн энэ төрлөөр зохион байгуулагдах семинар, сургалтад хамрагдах,
- Богино хугацааны сургалт,
- Урт хугацааны, давтамжит сургалт,
- Сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага, тэргүүний үйлдвэрийн газруудад мэргэшлээ дээшлүүлэх, ажлын туршлага олж авах сургалт,
- Аспирантур болон докторантурт суралцах,
- Шинэ мэргэжлийг эзэмших
- Мэргэшсэн инженерийн сургалт,

1.4 Мэргэжилтний тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэжлийн зэрэг олгох, сургах, цуцлах ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, цаашид энэхүү тогтолцоог тасралтгүй сайжруулж боловсронгуй болгоход салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх “Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөл” /цаашид Зөвлөл гэх/-ийн үйл ажиллагаа чиглэгдэнэ.

1.5 Мэргэжлийн зэрэгтэй мэргэжилтэн нь ажил үүргээ мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж, зэрэгтэй мэргэжилтний нэр хүндийг өргөж байхын тулд зохих багц цагийн мэргэжүүлэх болон чадавхижуулах сургалтуудад тогтмол хамрагдаж сургалтын тодорхой багц цагийг бүрдүүлэх, мөн техник, технологийн шинэ шийдлийг сэдэж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, зардлыг бууруулах, ажлын байрыг

автоматжуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн шинэ бүтээл, оновчтой саналыг дэвшүүлж хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрэх чиглэлд санаачлага гаргах үүрэгтэй.

2. МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

2.1 Төмөр замын салбарын мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1 Төмөр замын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг доорх нөхцөл шаардлагыг хангаснаар, эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас авсан байх;

2.1.2 Сургалтын байгууллага нь анги танхим, сургалтын материал, техник, тоног төхөөрөмжийн хувьд мэргэжлийн сургалтын байгууллагад тавигдах стандарт шаардлагыг бүрэн хангасан байх;

2.1.3 Сургалтын чиг хандлагад нийцсэн, салбарын мэргэжилтний чадавхийг сайжруулах талаар холбогдох төрийн байгууллагаар баталсан сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө, аргачлалтай байх;

2.1.4 Сургалтын байгууллага сургалт явуулах, шалгалт авах хүмүүсийн боловсрол, мэргэжлийн ур чадварын түвшинг тодорхойлох үнэлгээний талаар журамтай байх ба тэдгээрийн мэдлэг, ур чадвар, дадлага нь суралцагчдаас илүү байна гэдгийг нотлох шалгуур үзүүлэлт, түүний хэрэгжилтийг харуулсан байна.

2.1.5 Сургагч багш нар нь төмөр замын байгууллагад ажилладаг, **3.10.1.4**-т тавигдах нөхцөл, шаардлагыг хангасан зөвлөх зэрэгтэй инженер байж болох бөгөөд багшлах эрхийн гэрчилгээг холбогдох төрийн захиргааны байгууллагаас авсан байна.

2.1.6 Сургагч багш нь гадаад орны мэргэжлийн хамрах хүрээний Их, дээд сургуулийн багш, профессор мөн Олон улсын инженерүүдийн холбоо (FIDIC)-ы зөвлөх инженерийн гэрчилгээ бүхий инженерүүд байх тохиолдолд энэхүү журмын 2.1.5, 2.1.6-г тус тус мөрдөхгүй байж болно.

2.1.7 Сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах болон шалгалт авах тухай журмыг боловсруулсан байна.

2.1.8 Сургалтын байгууллага нь өөрсдийн ажилтан, багш нарт өөрийн зохион байгуулж байгаа сургалтын хүрээнд зэрэг олгох, сунгах тухай санал гаргахыг хориглоно.

2.1.9 Энэхүү журмын хавсралтаар заасан мэргэжлийн хүрээнээс бусад чиглэлээр мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалт зохион байгуулахыг хориглоно.

2.2 Сургалтын байгууллага нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.1 Сургалтын байгууллага нь өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэжлийн хамрах хүрээний хувьд 15 болон түүнээс дээш жилийн ажлын туршлагатай, шинжлэх ухааны хамгийн багадаа тэргүүлэх багш, аспирантурын зэрэг бүхий сургагч багшийн бүрэлдэхүүнтэй байна.

2.2.2 Холбогдох мэргэжлийн сургалтын байгууллагаар үнэлүүлсэн хөтөлбөр болон төлөвлөгөөний дагуу сургалтын нэг багц цагийн үнэлгээг тооцож, Зөвлөлөөр батлуулах;

2.2.3 Сургалтын байгууллага нь зэрэг горилох сургалт зохион байгуулахын өмнө сургалтад хамрагдахыг хүссэн мэргэжилтэнгүүдийн бүрдүүлж ирүүлсэн, зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэрэг горилогчийн хувьд энэхүү журамд заасны дагуу бүрдүүлж ирүүлсэн материалуудыг Зөвлөлд албан бичгээр хүргүүлж хянуулж санал авсны үндсэн дээр холбогдох сургалтыг зохион байгуулах эрх үүснэ.

2.2.4 Сургалтын байгууллага нь зэрэг горилогчдоос шалгалт авах, зөвлөхийн зэрэг горилогчдын хамгаалалтыг зохион байгуулахтай холбоотой гарах зардлыг өөрөө хариуцна.

2.2.5 Сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжилтэй ажилтныг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

2.2.6 Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх;

2.2.7 Сургалтын үйл ажиллагааны тайлан мэдээ, дүгнэлтээ хагас жил тутамд Зөвлөлд тайлагнах;

2.2.8 Сургалттай холбоотой бичиг баримт /хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, суралцагчдын судалгаа, шалгалтын материал, санал хүсэлт г.м/-ыг архивын нэгж болгон 5 жил хүртэл хугацаагаар хадгалах;

2.2.9 Мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлээр ижил төстэй мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах;

3. Сургалтын хөтөлбөр

3.1 Нэгдсэн хөтөлбөрт салбарын мэргэжилтнүүдэд зориулсан мэргэшүүлсэн сургалт болон тодорхой сэдвээр явагдах урт, богино хугацааны чадавхжуулах сургалтын төрлийг тогтоох ба эдгээр сургалтын чиглэл, сэдэв, сургалт явуулах хэлбэр, хугацааг нарийвчлан тусгасан байна.

3.2 Нэгдсэн хөтөлбөрт тусгагдсан аливаа сургалтыг агуулга, сэдвийн хувьд мэргэшүүлэх, чадавх

3.3 жуулах гэсэн чиглэлүүдээр Дээд боловсролын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмаар тогтоож, хүлээн зөвшөөрсөн сургалтын хэлбэрээр явуулж болно.

3.4 Нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгжийн дотоодын хөтөлбөрийг боловсруулж зохион байгуулахад салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажиллана.

3.5 Сургалт зохион байгуулах холбогдох эрхийг авсан байгууллага нь зохион байгуулахаар төлөвлөж буй сургалт хөтөлбөрийг Зөвлөлөөр хэлэлцүүлэх ба Зөвлөл сургалтын байгууллагаас холбогдох мэргэжлийн сургалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар үнэлгээ хийлгэж ирүүлэхийг шаардах эрхтэй.

3.6 Сургалтын хөтөлбөрт сургалтын нэр, зорилго, төрөл, чиглэл, цагийн багтаамж, олгогдох багц цаг, сургалт зохион байгуулах байршил болон хугацаа, сургалтад хамрах мэргэшлийн хүрээ, сургалтын товч агуулга, сургалтын үед ашиглах гарын авлага, тараах материал, суралцагчийн мэдлэг чадварыг сорих бодлого, дасгал асуулт, хариултын хамт тусгасан байх ба сургагч багш нарын CV, мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг илтгэсэн материалыг бүрдүүлж ирүүлсэн байна.

3.7 Чадавхижуулах нэг сургалтын хөтөлбөр нь 1 багц цагаас доошгүй, 6 багц цагаас илүүгүй хэмжээний, мэргэжүүлэх сургалтын хувьд хамгийн багадаа 4 багц цагаас багагүй багтаамжтай байх ба урт хугацааны сургалтын хувьд хөтөлбөрийг сэдвийн хувьд хэсэгчлэн баталж болно.

3.8 Сургалтын хөтөлбөр нь салбарын мэргэжилтний суралцах, мэдлэг, ур чадвар, мэргэжлээ дүүшлүүлэх эрэлт хэрэгцээнд түшиглэсэн байх ба агуулгын хувьд онолын мэдлэгээс гадна суралцагсад дадлагын ур чадвар олгоход чиглэсэн байна.

3.9 Мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр нь Мэргэжилтэн бүр өөрийн мэргэжлийн чиглэлээр жилдээ 10-аас доошгүй багц цагийг хангахуйц чадавхижуулах болон мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байхаар сургалтын хөтөлбөрийг боловсруулна.

4. ТАСРАЛТГҮЙ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ, БҮТЭЭЛИЙГ ҮНЭЛЭХ, БАГЦ ЦАГ ТООЦОХ

4.1 Салбарын мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтын багц цагийг танхимын хичээл болон танхимын бус үйл ажиллагааны хэлбэрээр хангаж болно. Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь танхимын сургалтын хэлбэрээр, зөвлөх мэргэжилтэн нь танхимын сургалтын хэлбэрээр нийт багц цагийн тус тус 30-аас доошгүй хувийг хангасан байна.

4.2 Мэргэшүүлэх сургалтын танхимын хичээлээр 16 цагийг сургалтын 1 багц цаг, чадавхижуулах сургалтын танхимын хичээлийн 32 цагийг сургалтын 1 багц цаг гэж тооцох ба

сургалтын хөтөлбөрийн агуулгыг Зөвлөл хэлэлцэн тухайн сургалтын багц цагийн хэмжээг батална.

4.3 Зэрэг горилогч нь байгууллагын ерөнхий инженер болон дүйцэхүйц албан тушаалтнаар баталгаажуулсан сүүлийн 3-5 жилд хийсэн бүтээлийн тайланг, үр дүнд хүрсэн талаар өгсөн мэдээлэл бүхий баримтжуулсан бүтээлийн тайланг загвар 1-ийн дагуу, зэрэг сунгах болон ахиулах мэргэжилтэн нь зэрэг авснаас хойш хийсэн бүтээлийн тайланг мэргэжил дээшлүүлсэн бодит цагийн хэмжээгээр тооцож, 2-оос доошгүй зөвлөх инженерээр хянуулан баталгаажуулж, үр өгөөжтэйг баталсан дүгнэлт бүхий Загвар 2-ын дагуу гаргаж нотлох баримт материалыг хавсаргасан байна.

ЗАГВАР 1

..... овогтой-ийн Бүтээлийн тайлан

огноо

№	Бүтээлийн нэр	Хамрах хүрээ	Өөрөө гүйцэтгэсэн, оролцсон, хэрэгжүүлсэн аль нь болох	Бүтээлийн хүрсэн түвшин, түүнийг нотолсон байдал, шүүмж хийлгэсэн эсэх	Гүйцэтгэсэн огноо

ЗАГВАР 2

..... овогтой-ийн мэргэжил дээшлүүлсэн тухай тайлан

огноо

№	Мэргэжил дээшлүүлсэн хэлбэр, агуулга, сэдэв	Огноо, Үргэлжлэх	Бүтээлийн хамрах хүрээ	Өөрөө гүйцэтгэсэн, оролцсон, хэрэгжүүлсэн аль нь болох	Бүтээлийн хүрсэн түвшин, түүнийг нотолсон байдал, шүүмж хийлгэсэн эсэх	Оногдох багц цаг

4.4 Салбарын мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох танхимын бус сургалтын багцыг дараах хэлбэрийн үйл ажиллагаагаар хангаж болно. Үүнд:

А. Мэргэжлийн хамрах хүрээний чиглэлээр хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандартын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан байх ба тухайн баримт бичиг нь батлагдсан бол **4 багц цаг**,

Б. Мэргэжлийн хамрах хүрээний чиглэлийн хууль эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандартад санал өгч тусгуулсан, шүүмж хийсэн тохиолдолд: **4 багц цаг**,

В. Мэргэжлийн заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан бол **5 багц цаг**,

Г. Мэргэжлийн ном, нэг сэдэвт бүтээл нийтлүүлсэн бол- **10 багц цаг**,

Д. Салбарын хүрээний сонин, сэтгүүл, хэвлэлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн бол нэг өгүүлэлд- **2 багц цаг**,

Е. Мэргэжлийн хамрах хүрээнд магистрийн зэрэг хамгаалсан бол **10 багц цаг**,

Ё. Мэргэжлийн хамрах хүрээнд докторын зэрэг хамгаалсан бол **30 багц цаг**,

Ж. Мэргэжлийн хүрээний болон салбарын чиглэлээр төсөл, холбогдох албан тушаалтны баталсан тушаалаар хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх ажлын хэсэгт орж ажиллан

ажлын тайлан нийтлэлийг нийтлүүлсэн бол тайлан тус бүрээр **4 багц цаг**-ийг ажилласан хүний тоогоор хувь тэнцүүлэн,

З. Шинээр бэлтгэсэн илтгэл, хичээлийн лекц, /Заасан сэдвийн чиглэлээр хичээлийн 4 цаг тутамд /-**1 багц цаг**,

И.Мэргэжлийн хамрах хүрээнд Их, Дээд сургууль төгсөгчийн дипломын ажил удирдсан /1 оюутан/-**0,5 багц цаг**,

К. Мэргэжлийн хамрах хүрээнд орчин үеийн технологийг ашиглан, үйлдвэрлэлийн үйл явцыг хялбаршуулах, автоматжуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зардлыг хэмнэсэн шинэ бүтээл гаргасан, холбогдох зохиогчийн эрхийн патент гэрчилгээг авсан, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн тохиолдолд: **20 багц цаг**,

Л. Шалгалтын асуулт, тест боловсруулсан бол / багц бүр нь 20 асуулттай 10 багц тест/-**0,5 багц цаг**,

М. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан бол: **0,5 багц цаг**

4.5 Зэрэг горилогчийн хийсэн бүтээл нь ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажлын хүрээнд хийгдсэн тохиолдолд бүтээлд тооцохгүй.

4.6 Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь танхимын бус хэлбэрээр багц цаг хангасан жагсаалтыг гарган, холбогдох албан тушаалтнуудаар баталгаажуулан, нотлох баримтуудыг хавсарган Зөвлөлд жил бүр хүргүүлж байна. Зөвлөл нь танхимын бус хэлбэрээр багц цаг олгох асуудлыг жил бүр хэлэлцэн шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

5 МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАГЦ ЦАГ ХАНГАХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

5.1 Мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг сунгах сургалтад хамрагдаж, мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь мэргэжлийн чиглэлээрээ 3 жил тутамд сургалтын 30 багц цаг, зөвлөх мэргэжилтэн нь мэргэжлийн чиглэлээрээ 5 жил тутамд 40 багц цагийг дараах байдлаар хангасан байна.

5.2 Мэргэшүүлэх чиглэлийн сургалтаар нийт хангах шаардлагатай багц цагийн 60%, чадавхжуулах чиглэлийн сургалтаар нийт хангах шаардлагатай багц цагийн 40%-ийг тус тус хангасан байна.

5.3 Энэхүү журмын 4.4-д дурдсан аль нэг чиглэлээр хангасан багц цагийн илүү хэсгийг нөгөө чиглэлийн багц цагт оруулж тооцохгүй.

5.4 Мэргэжилтэн нь танхимын сургалтын багц цагийг жигд хангаж байхын тулд жил бүр дунджаар 10 багц цагийн сургалтад хамрагдсан байвал зохино.

5.5 Мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн чиглэлээр танхимын бус хэлбэрээр багц цагаа хангахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй.

5.6 Гадаад дотоодын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөртэй сургалтад хамрагдсан мэргэжилтэнд тухайн хөтөлбөрт заасан хэмжээний сургалтын багц цагийг олгоно.

5.7 Мэргэжилтэн нь тухайн жилд ногдох багц цагаа хангаагүй бол дараа жил нөхөн гүйцээж болно.

6 МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ, БАГЦ ЦАГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

6.1 Мэргэжилтэн бүр мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилдох, сунгах танхимын болон танхимын бус сургалтад хамрагдаж багц цаг хангаснаа нотлох үүрэг хүлээх ба энэ талаарх жилийн тайланг тухайн жилийн 12 сарын 1-нээс 15-ны хооронд багтаан Зөвлөлд ирүүлнэ.

6.2 Сургалт зохион байгуулсан байгууллага нь тухайн сургалтад хамрагдаж багц цаг хангасан мэргэжилтнүүдийн нэрс болон холбогдох материал, сургалтын тайлан, шалгалтын комиссын санал зэргийн тухайн сургалт явагдаж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Зөвлөлд хүргүүлнэ.

6.3 Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилдох, сунгах сургалт болон сургалтад хамрагдсан

мэргэжилтнүүдийн талаарх энэхүү журмын 2 дугаар хэсгийн 2.5.18-д заасан бүтэцтэй мэдээлэл бүхий нэгдсэн мэдээллийн санг хөтөлнө.

7. БАГЦ ЦАГ ХАНГААГҮЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1 Мэргэжилтэн нь мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилох, сунгах сургалтад хамрагдсан болон сургалтын багц цаг хангасан талаарх өөрийн мэдээлэл, бүртгэлтэй танилцах, лавлагаа авах, буруу мэдээллийг өөрчлөх, засвар оруулахыг шаардах эрхтэй.

7.2 Зөвлөл нь мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд сунгалтын багц цаг хангаагүй мэргэжилтний мэргэжлийн зэргийг цуцлах асуудлыг хэлэлцэхээс 2 сараас доошгүй хугацааны өмнө тухайн мэргэжилтэнд энэ тухай урьдчилан мэдэгдэнэ.

7.3 Сургалтын багц хангаагүй мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх чиглэлд холбогдох сургалтад хамрагдаж сургалтын багц цаг хангаагүй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол түүнийг нотолж, албан ёсоор тайлбар бичиж Зөвлөлд хүргүүлэх ба дахин жилийн хугацаанд холбогдох мэргэжлийн хүрээнд давтан суралцсаны дараа сунгуулах тухай хүсэлт гаргах эрх үүснэ.

7.4 Мэргэжилтэн 3 жилийн хугацаанд багц цагаа хангаагүй бол мэргэжлийн зэргийг цуцлах асуудлыг Зөвлөлөөр эцэслэн шийдвэрлэнэ.

8. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1 Зөвлөл нь мэргэжилтний мэргэжлийн мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадварыг эрх бүхий шалгалтын комиссын зохион байгуулсан шалгалтаар, харин ажлын бүтээл, туршлага, бүтээлийн тайланг салбарын технологийн зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг үндэслэн зохих журмын дагуу магадлан шалгах замаар үнэлнэ.

8.2 Шалгалтын комисс нь ажиллах дотоод журамтай байна.

8.3 Мэргэжлийн зэрэг олгох шалгаруулалт нь мэргэшлийн зэрэг горилогчид 1, зөвлөх зэрэг горилогчид 2 үе шаттайгаар явагдана. Үүнд:

а. Нэгдүгээр шат: Мэргэжлийн шалгалт / мэргэжлийн чиглэлийн мэдлэг, ур чадвар болон салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, журам, зааврын талаарх мэдлэгийг шалгах/

б. Хоёрдугаар шат: Тайлан, сэдвийн хамгаалалт /илтгэлийн хураангуй (илтгэл) бичих, техник, технологийн шийдэл, зураг төсөл, төсөвт экспертиз хийх/

8.4 Мэргэшсэн зэрэг горилогч нь мэргэжлийн болон мэргэжлийн ур чадварын шалгалтад авбал зохих нийт онооны 80 буюу түүнээс дээш хувь, зөвлөх болон тэргүүлэх зэрэгт ахиулан горилогч нь 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн бол тэнцсэнд тооцно.

8.5 Мэргэжлийн шалгалтыг бичгээр, *тест, зураг тооцоо, загвар зэргээр авна.*

8.6 Зэргийг сунгуулж буй мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн чиглэлээр норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичиг боловсруулсан болон санал, шүүмж, дүгнэлтийг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн материалаа мэдээллийн сан болон архивын нэгж болон хадгалуулсан байна. Энэхүү санал, дүгнэлтээ тайлан хамгаалалтад бүрдүүлэх материалд хавсаргасан байна.

8.7 Мэргэжлийн шалгалтыг бичгээр болон тестээр, тайлан хамгаалалт болон ур чадварын шалгалтыг тухайн горилогчийн мэргэжлийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын бүтээл, ур чадварын түвшинг ярилцлагын хэлбэрээр авна.

8.8 Шалгалтын комисс нь сургалтын байгууллагаас өгсөн шалгалтын тестийн сангаас тест бодлого, өгөгдлийг сонгох бөгөөд энэ нь шалгалт авах өдөр, цаг хүртэл шалгалтын комиссын нууцад хамаарна.

8.9 Зэрэг горилогчийн авсан нийт онооны нийлбэрийг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн дүгнэж, дундаж оноог гаргах ба энэ дүнг комиссын гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан байна.

8.10 Зөвлөх зэрэг горилогч нь Зөвлөлөөс өгсөн сэдвээр хийсэн хамгаалалтын материалаа товлосон хугацаанаас 1 сараас багагүй хугацааны өмнө Технологийн зөвлөлийн нарийн бичигт өгсөн байна. Хамгаалалтын товыг холбогдох шалгалтаар амжилттай үнэлэгдсэн тохиолдолд Технологийн зөвлөл товлон.

8.11 Зөвлөх зэрэг горилогчийн илтгэл /реферат/-ийг Технологийн зөвлөлөөс салбарын тухайн мэргэжлийн чиглэлийн зөвлөх зэрэгтэй болон эрдмийн зэрэг, цолтой мэргэжилтнээр

шүүмжлүүлэх ажлыг зохион байгуулна. Технологийн зөвлөл нь илтгэл /реферат/-ийн шүүмжлэгчийг горилогчоос нууцална.

8.12 Комиссын гишүүд нь горилогчийн илтгэл, тайланг түүний онол, техник-технологийн түвшин, мэдээлэл боловсруулалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж, шинэлэг санаа ач холбогдол, асуултад хариулсан байдал, шүүмжийн үнэлгээ, дүгнэлт зэрэг үзүүлэлтээр дүгнэнэ.

8.13 Комиссын нарийн бичгийн дарга нь шалгалтын нэгдсэн дүн, комиссоос гаргасан горилогч тус бүрийн хувьд өгсөн дүгнэлт бүхий санал болон горилогчтой холбоотой бүхий л материалыг цэгцэлж, шалгалт дууссанаас хойш нэг сарын дотор Зөвлөлийн гишүүн бүрд хүргэж танилцуулан, хурлаар шийдвэрлүүлнэ. Шалгалтын үнэлгээн дээр маргаантай асуудал гарвал горилогч гомдол саналаа Зөвлөлд бичгээр гаргаж шийдвэрлүүлж болно.

8.14 Зөвлөх инженерийн зэрэг горилогчийн хувьд тухайн зэргийг олгохтой холбоотой шийдвэрийг Технологийн зөвлөлөөс бүтээлийн хамгаалалтаас гарсан үр дүнгийн талаарх санал, шалгалтын комиссын шалгалтын үнэлгээ, мөн туурвисан бүтээлүүд, хамгаалсан бүтээл, түүнд хийсэн шүүмж, багц цагийн бүрдүүлэлт, шаардлагатай нотолгоог ирүүлснийг үндэслэн Зөвлөл шийдвэрлэнэ.

8.15 Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажуулна.

8.16 Тушаал гарсантай холбогдуулан холбогдох сургалтыг зохион байгуулсан сургалтын байгууллага нь зэргийн гэрчилгээтэй холбоотой үйл ажиллагааг ажлын 15 хоногт багтаан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Гэрчилгээний эх болон баталгааны тэмдгийн загварыг “Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох нийтлэг дүрэм”-ийн хоёрдугаар хавсралтад үзүүлснээр хэвлүүлсэн байна.

8.17 Зөвлөлийн шийдвэрт төрийн захиргааны төв байгууллагын зүгээс хяналт шалгалт хийж болно.

8.18 Шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хянагчаас гадна мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч хяналт тавьж болно.

8.19 Технологийн зөвлөл болон комиссын гишүүдэд нөлөөлөхийг оролдсон, горилогчийг үндэслэлгүйгээр илт дэмжиж, бусдаас хэт зөрүүтэй үнэлгээ тавьсан гишүүнийг комисс хэлэлцэж, түүний үнэлгээг комисс хэлэлцэж, түүний үнэлгээг комиссын нэгдсэн дүнд оруулах эсэхийг санал авч шийдвэрлэнэ.

9. ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ СЭДВИЙН ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙ.

9.1 Илтгэлийн хураангуй нь төмөр замын тээврийн салбарт болон мэргэжлийн хамрах хүрээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалт, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдсэн, тодорхой үр дүнд хүрсэн, шинжилгээ судалгаа бүхий онол практикийн бага хурлын илтгэлийн түвшинд бичигдсэн, тодорхой асуудал дэвшүүлж шийдвэрлэх арга замыг заасан байвал зохино.

9.2 Илтгэлийн хураангуйг бичих чиглэл, сэдвийг дараах байдлаар сонгоно.

9.2.1 Баталсан сэдвийн жагсаалтаас сонгох,

9.2.2 Зөвлөлөөс зөвшөөрсөн сэдвээр,

9.2.3 Зөвлөлөөс оноож өгсөн сэдвээр.

9.3 Энэхүү журмын 9.2.1-ийн дагуу сонголт хийх зэрэг горилогч нь холбогдох сургалтад хамрагдахаас 3 сараас доошгүй хугацааны өмнө сэдвийг сонгох ба энэ тухай урьдчилан Зөвлөлд бичгээр мэдэгдэж бүтээлийг холбогдох сургалтад хамрагдаж амжилттай үнэлгээ авсны дараа шууд хамгаална.Хамгаалалтыг Зөвлөлөөс зохион байгуулна.

9.4 Зэрэг горилогч нь энэхүү журмын 9.2.2 - 9.2.3-ийн дагуу бүтээлийн сонголт хийх тохиолдолд холбогдох сургалтад хамрагдахад бүтээлийн сэдвийг авах ба амжилттай үнэлгээ авсны дараа 3 хүртэлх сарын дотор сэдвийн хамгаалалтыг хийж болно.

9.5 Илтгэлийн хураангуйг 15-25 хуудсанд (Агаил , 12) багтаан бичих ба оршил, асуудлын судлагдсан байдал, судалгаа боловсруулалт, хэрэгжүүлэлт, туршилт, тухайн ажлын үр дүн, санал дүгнэлт, ашигласан материалын жагсаалт, хавсралт зэргээс бүрдэнэ.

Оршил: Зөвлөх инженерийн зэрэг горилж буй сэдвийн ач холбогдол, түүний шинэлэг талын тухай болон илтгэлийн ерөнхий байдлыг товч дүгнэж бичнэ. Энэ сэдвээр горилогч

нь ямар зүйл бүтээсэн, туршсан үйлдвэрлэлд нэвтрүүлсэн (өөрийн хийсэн зураг, төсөл, норм норматив, заавар, журам, машин техник, технологи, удирдлага зохион байгуулалтын шинэ арга барил, хэвлүүлж нийтлүүлсэн нийтлэл, ном, зохиол, шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлага зэрэг эдийн засгийн үр өгөөжийн тооцоо эерэгээр гарсан) бүтээл нь байгууллага, салбар болон холбогдох дээд түвшинд хэлэлцэгдсэн, дэмжигдсэн эсэхүл батлагдсан, хэрэгжиж байгаа, патентын гэрчилгээ авсан, авах шатандаа яваа, олон улсын хэмжээний салбарын сэтгүүл, хэвлэлд нийтлэгдсэн зэрэг хүрсэн үр дүнг дурдана.

Асуудлын судлагдсан байдал: тухайн сэдвээр гадаадын улс орнууд болон манай оронд судлагдсан байдал, онолын үндэслэл, ямар үр дүнд хүрсэн байсан тухай бичнэ. Мөн судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, туршилтын ямар арга хэрэглэж юу бүтээсэн, түүний урд нь байсан үйлдвэрлэлийн үзүүлэлт болон хөгжингүй орны техник, эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулсан судалгаа, дүгнэлтийг хийсэн байна.

Судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт, туршилт: энэ сэдвээр явуулсан судалгаа, туршилтын ажил болон үйлдвэрлэлд нэвтрүүлснээр гарсан бодит үр дүнг биет болон тоон үзүүлэлтээр гаргах, түүний нийгэм, эдийн засгийн ач холбогдол, тулгамдсан ямар асуудлыг шийдвэрлэсэн буюу шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлснийг тодорхой тусгана.

Ажлын үр, дүн: энэ сэдвээр гаргасан шинэ санаа эсвэл онцлог шинэлэг зүйл юу байгаа, цаашид үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх эрх зүйн орчин, түүхий эд, технологи, машин механизм, тоног төхөөрөмж, ажиллах боловсон хүчний хангамжийн асуудал учирч болох бэрхшээл, шийдэх тулгамдсан асуудлууд зэргийг багтаасан байна.

Санал дүгнэлт: энэ асуудал олон улсын болон хөгжилтэй орны хэмжээнд ямар байгаа, манай орны нөхцөлд шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд гарч болох түвэгшилтэй маргаантай асуудлууд юу байгаа, тэдгээрийг ямар арга замаар хэрхэн шийдвэрлэх тухай өөрийн үзэл бодлоо үндэслэл, тооцоотой гаргана.

Ашигласан хэвлэл, материалын жагсаалт: сэдвийг боловсруулахад ашигласан гадаад, дотоодын хэвлэл, сурах бичиг, норм, дүрэм, заавар журам, интернэтийн мэдээллийн линкийг жагсааж бичнэ. Ашигласан материал нь илтгэлийн хураангуй дотор заавал иш татагдсан эсвэл дугаараараа заагдсан байна.

Хавсралт: Сэдвийн судалгаа, туршилтын үр дүн, түүнд холбогдох хүснэгт, график зураг, үзүүлэн материалыг хавсаргана. Мөн сэдвийн хамгаалалтын дүнд хэрэглэх зарим биет үзүүлэн, загвар, альбом байж болно. Хавсралт материалын тоо хэмжээнд тодорхой хязгаарлалт байхгүй бөгөөд энэ нь рефератын ерөнхий хэмжээнд орохгүй.

9.6 Хураангуй илтгэлийн нүүр нь төрийн захиргааны байгууллага, сургалт зохион байгуулсан байгууллага, горилогчийн нэр, зэрэг, албан тушаал зэргийг агуулсан байна. Илтгэлийн товчлолыг зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр нийтийн хүртээл болгож болно.

10. МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, СУНГАХ, ЦУЦЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

10.1 Мэргэшлийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагаанд энэхүү журмын хавсралтад заасан мэргэжил дээшлүүлэх тогтолцооны бүдүүвч, мэргэшлийн зэрэг олгох мэргэжилтэнд тавигдах шаардлагыг мөрдлөг болгон ажиллана.

10.2 Энэхүү журмын дагуу олгогдсон мэргэжлийн зэрэгтэй мэргэжилтэн нь ажил үүргээ мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж, зэрэгтэй мэргэжилтний нэр хүндийг өргөж байхын тулд мэргэжүүлэх болон чадавхжуулах сургалтад тогтмол хамрагдаж сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүргийг хүлээнэ.

10.3 Гадаад улсын болон өөрийн орноос “Олон улсын зөвлөх инженерүүд”-ийн холбооны сүүлийн 3 жилийн хугацаанд авсан зөвлөх инженерийн хүчинтэй гэрчилгээ бүхий Монгол Улсын иргэн Зөвлөлд зэрэг горилон хүсэлт гаргасан тохиолдолд Технологийн Зөвлөл нь сүүлийн 3 жилд хийсэн төмөр замын салбарын барилгын, эрхзүйн орчны, гэрээ эрх зүйн, чанарын тогтолцооны чиглэлээр хийсэн бүтээл, ажлын үр дүнг харуулсан баталгаажуулсан материалыг судалж үзсэний үндсэн дээр шалгалт авахгүйгээр, сэдвийг хамгаалуулж Монгол

Улсын Зөвлөх инженерийн зэргийг мэргэжлийн хамрах хүрээний ижил төстэй чиглэлээр хугацаагүйгээр олгож болно.

10.4 Энэхүү журмаар тогтоосон мэргэжлийн хамрах хүрээгээр болон ижил төстэй чиглэлд гадаад улсад ажиллах, суралцах хугацаандаа салбарын чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдаж зөвлөх үйлчилгээ, төслийн эдийн засгийн үр өгөөжийн тооцоо судалгаа хийсэн, оролцсон, мэргэжлийн чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэл хэвлүүлсэн зэрэг бүтээлийн тайланг хийсэн нь сүүлийн 4-5 жилийн байдлаар холбогдох бичиг, баримт, баталгаатай тамга тэмдэг бүхий эрх бүхий байгууллагын зүгээс тодорхойлогдсон иргэн холбогдох зэрэг горилох тухай хүсэлтийг Зөвлөлд бичгээр гаргаж шийдвэрлүүлж болох ба энэ тохиолдолд Зөвлөл нь холбогдох бүтээлийг судалж хэлэлцүүлсний үндсэн дээр мэргэжлийн хамрах хүрээ болон түүнтэй адилтгах чиглэлээр Монгол Улсын Зөвлөх инженерийн цолыг 1 удаа 5 жилийн хугацаагаар олгох ба дараагийн удаагаас хугацаагүйгээр олгоно.

10.5 10.3-т заасан нөхцөл шаардлагыг хангасан мэргэжлийн хамрах хүрээний мэргэшсэн инженер нь мэргэшсэн инженерийн зэрэг горилох тухай хүсэлтийг Зөвлөлд бичгээр гаргаж болох ба энэ тохиолдолд мэргэжлийн хамрах хүрээгээр Монгол Улсын Мэргэшсэн инженерийн цолыг 1 удаа 5 жилийн хугацаагаар олгох ба дараагийн удаагаас хугацаагүйгээр олгоно.

10.6 10.4-ийн дагуу нөхцөл шаардлагыг хангасан мэргэжлийн хамрах хүрээний мэргэшсэн инженер нь зөвлөх инженерийн зэрэг горилох хүсэлтийг Зөвлөлд гаргаж болох ба энэ тохиолдолд Зөвлөл нь салбарын шийдэл шаардаж, тулгамдсан, мэргэжлийн ур чадвар, мэргэшил шаардсан сэдвээр судалгаа, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо, зураг төсөл боловсруулах, хянах даалгаврыг өгч шалгах эрхтэй ба судалгааг бэлэн болсны дараа сэдвийг хамгаалуулах, Монгол Улсад мөрдөж байгаа мэргэжлийн стандарт, эрх зүйн орчны талаар бичгээр болон амаар авсан шалгалтаар амжилттай дүгнэгдсэн тохиолдолд Монгол Улсын Зөвлөх инженерийн зэргийг шинээр олгох ба 1 удаа сунгуулсны дараа хугацаагүй олгоно.

10.7 Мэргэжлийн хүрээний чиглэлээр доктор (academic)-ын зэрэг хамгаалсан Зөвлөх зэрэг горилогчийн Зөвлөлд бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлөх ба мэргэжлийн хамрах хүрээнд шийдэл шаардаж, тулгамдсан, мэргэжлийн ур чадвар, мэргэшил шаардсан сэдвээр судалгаа, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо, зураг төсөл боловсруулах, хянах даалгаврыг өгч, тайлан тавиулах ба хамгаалалтад 90-с доошгүй оноо авсан тохиолдолд холбогдох зэргийг олгох тухай асуудлыг Зөвлөл хуралдаж шийдвэрлэх ба 1 удаа сунгасны дараа зэргийг хугацаагүйгээр олгож болно.

10.8 Сургалтад хамрагдсан шалгалт өгөх эрх бүхий зэрэг горилогч нь нотлох баримт бүхий хүндэтгэх шалтгаанаар шалгалтад орж амжаагүй, эсвэл тэнцээгүй тохиолдолд тухайн чиглэлээр 3-6 сарын дотор явагдах дараагийн сургалтад хамрагдалгүйгээр зөвхөн шалгалтад хамрагдах эрхтэй. Харин тэрхүү шалгалтад хамрагдаагүй тохиолдолд мэргэжлийн зэрэг горилох сургалтад заавал хамрагдсанаар дахин шалгалт өгч үнэлүүлнэ. Сүүлийн тохиолдолд сургалтын төлбөрийн 30-аас дээшгүй хувийг төлөхөөр зохион байгуулна.

10.9 Холбогдох сургалтад хамрагдсан зөвлөх инженерийн зэрэг горилогч нь шалгалт болон бүтээлийн тайланг хамгаалах ажиллагаанд нотлох баримт бүхий хүндэтгэх шалтгаанаар амжаагүй тохиолдолд тухайн чиглэлээр 3-6 сарын дотор өөрийн бэлтгэсэн сэдвийг хамгаалж хамрагдах эрхтэй.

10.10 Зөвлөх инженерийн зэрэг горилогч нь 10.8-д заасны дагуу хамгаалалтад хамрагдаагүй тохиолдолд дахин хамгаалах хүсэлтийг Зөвлөлд бичгээр гаргана. Энэ тохиолдолд Зөвлөл шалтгаанаас үл хамааран зэрэг горилох бүтээлийн сэдвийг шинээр олгох ба зэрэг горилогч нь 3 сараас илүүгүй хугацаанд боловсруулж Зөвлөлд ирүүлнэ.Цааш нь хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь энэхүү журмын дагуу явагдана.

10.11 Энэхүү журмын 10.7-10.10-д тусгасан үйл ажиллагааг тухайн зэрэг горилогчийн холбогдох сургалтад хамрагдсанаас хойш хуанлийн 1 жилийн дотор багтаан гүйцэтгэж зэрэг шинээр олгох, сунгах асуудлыг шийдвэрлэсэн байна.Тухайн хугацаа дууссан тохиолдолд холбогдох сэргээх, чадавх дээшлүүлэх (мэргэжил дээшлүүлэх) сургалтад хамрагдсаны үндсэн дээр 2 жилийн дараа зэрэг горилох тухай хүсэлт гаргах эрх үүснэ.

10.12 Мэргэжлийн хамрах хүрээнд шийдэл шаардсан, тулгамдсан сэдвээр судалгаа, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо, зураг, төсөл боловсруулах чиглэлийн даалгаврыг энэхүү журмын 9.2-т заасан тухайн сэдвийг авснаас хойш 3 сар хүртэл хугацаанд боловсруулж хамгаалах хүсэлтийг Зөвлөлд бичгээр гаргаж шийдвэрлүүлнэ. Зөвлөлийн зүгээс тухайн хүсэлтийг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж товыг тогтоож, цаашид энэхүү журмын дагуу ажиллана.

10.13 Хэрэв энэхүү хугацаанд зэрэг горилогч ямар нэг хүндэтгэх шалтгаанаар (өвдөх, гадаадад томилолтоор ажилласан тухай холбогдох нотлох баримттай тохиолдолд) хамгаалж чадахгүй тухай бичгээр гаргасан тохиолдолд хүсэлтийг үндэслэн Зөвлөлийн зүгээс тухайн хугацааг хүсэлт гаргасан өдрөөс тооцон дахин нэг удаа 2 сар болон түүнээс ихгүй хугацаагаар сунгана.

10.14 Энэхүү журмын 10.12-10.13 -аар тогтоосон хугацаанд зэрэг горилогчийн зүгээс хамгаалах хүсэлт гаргаагүй тохиолдолд зэрэг ахиулахгүйгээр өөрийн мэргэшлийн зэргийн сургалтад сунгах хэлбэрээр сурах эрхтэй болно.

10.15 Зэрэг горилох, сунгах, зэрэг ахиулах мэргэжилтэн нь энэ журмын хавсралтад дурдсан зэрэг горилогчдод тавигдах шаардлагыг хангасан байна.

10.16 Зэрэг горилогч нь сургалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө дараах болон энэхүү журмын хавсралтад заасан баримт, бичгийг бүрдүүлж, сургалт зохион байгуулах байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- 1) Мэргэшлийн зэрэг олгох шалгаруулалтад хамрагдахыг хүссэн өргөдөл, анкет/загварын дагуу/,
- 2) 3x4 хэмжээтэй 2 хувь зураг,
- 3) Мэргэжлийн дипломын баталгаажсан хуулбар,
- 4) Мэргэжлийн хүрээнд ажилласан хугацаанд гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх 70 кредит цагаас доошгүй багцын сургалтад хамрагдсан, дээшлүүлсэн талаарх үнэмлэх, гэрчилгээний баталгаажсан хуулбар
- 5) Ажил олгогчийн болон тухайн мэргэжлийн хүрээний чиглэлийн зөвлөх, мэргэшсэн инженерийн зэрэгтэй 2-оос доошгүй мэргэжилтнээр баталгаажуулсан бүтээлийн тайланг загварын дагуу хавсралтаар гаргаж, боловсруулсан, батлуулсан, дэмжүүлсэн норм, дүрэм, стандарт, бичсэн ном, гарын авлага, нийтлэл, бүтээлийн фото хэлбэр, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар, гүйцэтгэсэн, боловсруулахад оролцсон зураг төсөл, төсвийн талаарх мэдээллийг шаардлагатай тодорхойлолт, материалуудын хамт хавсаргана.

10.17 Мэргэшсэн инженерийн зэргийг эхний удаа 3 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 3 жилээр 2 удаа сунгах ба энэхүү хугацаа дууссанаас хойш мэргэжлийн хамрах хүрээнд 5 жил үр бүтээлтэй ажилласан, мөн тавигдах шалгуурыг хангасан бол мэргэжлийн хамрах хүрээнд зөвлөх инженерийн зэрэг горилох эрх үүснэ.

- a. Зөвлөх инженерийн зэргийг энэхүү журмын 10.3-10.7-д зааснаас бусад тохиолдолд мэргэшсэн инженерийн зэргийг авч журмын дагуу 2 удаа 3 жилээр сунгуулсан, мэргэжлээрээ сүүлийн 8 жил ажилласан мэргэжилтэнд эхний удаа 3 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 5 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүйгээр олгоно.
- b. Энэхүү журмаар тогтоосон хугацаанаас өмнө мэргэшлийн зэргийг сунгах, ахиулахаар гаргасан хүсэлтийг шийдвэрлэхийг хориглоно.
- c. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хийсэн ажлын явцад энэхүү журмын 2.5.15-д заасан үндэслэлээр, мөн бусад холбогдох зөрчил илэрсэн тохиолдолд мэргэжилтний мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэргийг 3 хүртэлх жилийн хугацаагаар цуцлах эрх үүснэ.
- d. Мэргэжилтэн мэргэшлийн зэргийг цуцлах хугацаа дуусгавар болсон тохиолдолд Зөвлөлд зэргийг горилсон хүсэлтийг бичгээр гарган холбогдох

сургалтад хамрагдаж болно. Энэ тохиолдолд зөвлөх инженерийн гэрчилгээний үйлчлэх хүрээг бууруулж мэргэшсэн инженерийн зэргийн сунгалтаар, харин мэргэшсэн инженерийн хувьд сунгах биш шинээр олгохоор тооцно.

е. Мэргэшлийн зэргээ цуцлуулсан мэргэжилтэн Зөвлөлд энэхүү журмын 2.5.16-ын дагуу гэрчилгээ, баталгааны тэмдгийг хураалгах үүрэгтэй.

ф. Бүтээлээ худал мэдүүлэх, эсвэл бусдын бүтээлийг ашигласан нь тогтоогдвол мэргэшлийн зэрэг олгох, сунгахаас татгалзах, 3-аас доошгүй жилийн дараа дахин холбогдох мэргэшлийн зэрэг горилох сургалтад хамрагдах эрх үүснэ.

11. МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧИЙН ЁС ЗҮЙН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

11.1 Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтална.

11.2 Мэргэшсэн мэргэжилтэн нь техник-технологийн шинэлэг ололт амжилт, хууль эрх зүйн болон удирдлагын шинэ нэмэлт өөрчлөлтүүдтэй өөрийн мэргэжлийн ур чадварын болон мэдлэгийн түвшинг тогтмол, сэргээх, сурах үүрэгтэй.

11.3 Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь мэргэжлийн ажил, үйлчилгээ, шинжээчээр ажиллахдаа шударга ёс, бодит байдал, мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар, хянамгай байх, хараат бус байдал, мэдээллийн нууцыг хадгалах, техник, арга зүйн стандартуудыг баримтлах, мэргэжлийн нэр хүндийг дээдлэх зэрэг зарчмыг баримтална.

11.4 Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь өөрөө болон ах, дүү, эхнэр хүүхдийн оролцсон зураг төслийн ажилд шинжээч хийх эрхгүй.

11.5 Мэргэшсэн мэргэжилтэн мэргэшсэн зэргийн гэрчилгээ болон тэмдгийг бусдад шилжүүлж ашиглахыг хориглох ба энэ тохиолдолд мэргэшсэн мэргэжилтний ёс зүйг зөрчсөн байна гэж үзэн гэрчилгээг хүчингүйд тооцон дахин мэргэшлийн зэрэг олгохоос татгалзана.

---***---